



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 111

Номгон

**“Аймгаараа шатарчин болох хөдөлгөөн”  
өрнүүлэх тухай**

Аймгийн хэмжээнд шатрын спортыг эрчимтэй хөгжүүлэх замаар монгол хүний авъяас, ур чадварыг нээн илрүүлэх, энэхүү спортоор олон улс, тив, дэлхийд өрсөлдөж, амжилт гаргах өндөр зэрэглэлийн тамирчдыг тасралтгүй бэлтгэх, шатрын спортоор аймаг, орноо сурталчлах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Шатрын спортыг хөгжүүлэх зорилгоор “Аймгаараа шатарчин хөдөлгөөн”-ийг 2019-2022 онд аймгийн хэмжээнд өрнүүлсүгэй.
2. Хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлэх ажлын төлөвлөгөө гарган, төсвийг батлуулж, үр дүнтэй ажил зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190095